



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар,
зураглалыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.8 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн ерөнхий загвар, зураглалыг нэгдүгээр, хүний их эмчийн хөгжлийн загвар, зураглалыг хоёрдугаар, нүүр амны их эмчийн хөгжлийн загвар, зураглалыг гуравдугаар, уламжлалт анагаахын их эмчийн хөгжлийн загвар, зураглалыг дөрөвдүгээр, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний хөгжлийн загвар, зураглалыг тавдугаар, био-анагаахын мэргэжилтний хөгжлийн загвар, зураглалыг зургаадугаар, эм зүйчийн хөгжлийн загвар, зураглалыг долоодугаар, сувилагчийн хөгжлийн загвар, зураглалыг наймдугаар, эх баригчийн хөгжлийн загвар, зураглалыг есдүгээр, эм найруулагчийн хөгжлийн загвар, зураглалыг аравдугаар, эмнэлгийн лаборантын хөгжлийн загвар, зураглалыг арваннэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан хөгжлийн загвар, зураглалтай нийцүүлэн эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт, төгсөлтийн дараах сургалтын мэргэжлийн индексийг шинэчлэх ажлыг тус тус зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярт)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 113 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 оны...
дугаар сарын 14-ны өдрийн 168
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эмнэлгийн мэргэжилтний хөгжих замналыг тодорхойлох, хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд энэхүү загварын зорилго оршино.

1.2 Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар нь нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид элсэхээс эхлэн боловсрол эзэмших, мэргэжил, боловсролын хувьд өсч, хөгжих, шатлан ажиллах, албан тушаал ахих боломжуудыг тодорхойлно.

1.3 Эмнэлгийн мэргэжилтний боловсролын зэрэг, мэргэшсэн байдал, ажил мэргэжлийн туршлага нь бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллах албан тушаал, түүний ангилал, зэрэглэлтэй уялдана.

1.4 Энэхүү загвар нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлээрээ тогтвортой ажиллах, ур чадварыг нь хөгжүүлэх, нэмэгдэл урамшуулал олгох үндэслэл болно.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

Энэхүү бодлогын баримт бичигт хэрэглэсэн зарим нэр томъёог дор дурдсанаар ойлгоно:

2.1 “анагаах ухааны боловсрол олгох сургууль” гэж эмнэлгийн мэргэжлийн суурь боловсрол эзэмшүүлэх болон төгсөлтийн дараах сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургалтын байгууллагыг;

2.2 “эмнэлгийн мэргэжилтэн” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5-д зааснаар;

2.3 “албан тушаал” гэж эмнэлгийн мэргэжилтний ажлын байрыг;

2.4 “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.3-т зааснаар;

2.5 “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллахыг баталгаажуулсан баримтыг;

2.6 “Мэргэжлийн зэрэг” гэж эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг баталгаажуулсан үнэлгээг;

2.7 “Боловсролын зэрэг” гэж иргэний эзэмшсэн боловсролын түвшинг;

- 2.8 “Багц цаг” гэж Боловсролын тухай хуулийн 3.1.8–д зааснаар;
- 2.9 “Төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт” гэж нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөнөөс хойш мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх бүхий л хугацаанд эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхээр хийж буй сургалтыг;
- 2.10 “Үндсэн мэргэшлийн сургалт” гэж эмнэлгийн мэргэжилтнийг анагаахын шинжлэх ухааны тодорхой чиглэлээр 1,5 жилээс доошгүй хугацаагаар сургах сургалтыг;
- 2.11 “Төрөлжсөн мэргэшлийн сургалт” гэж эмнэлгийн мэргэжилтнийг үндсэн мэргэшлийн дагуу нарийсган мэргэшүүлж, 6 сараас доошгүй хугацаагаар сургах сургалтыг;
- 2.12 “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого” гэж салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжил, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаанд ойрын 5 жилд баримтлах чиглэлийг;
- 2.13 “Эрүүл мэндийн байгууллага” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.4-д зааснаар;
- 2.14 “Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөө” гэж тухайн байгууллагын ойрын 3-5 жилийн хугацааны хүний нөөцийн хэрэгцээ, түүнийг нөхөх төлөвлөлт, хүний нөөцийг чадавхижуулах үйл ажиллагааны багцыг;
- 2.15 “Мерит зарчим” гэж эмнэлгийн мэргэжилтнийг албан тушаал дэвшүүлэхдээ мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлийг гол хэмжүүр болгохыг;
- 2.16 “Суурь боловсролтой иргэн” гэж ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгсөгчийг;
- 2.17 “Хөгжлийн зураглал” гэж эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар ыг хялбаршуулсан дүрслэлийг.

Гурав. Хөгжих боломж, чиглэл

- 3.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэн, оюутан элсүүлэх хяналтын тоонд багтвал сонгосон мэргэжлээрээ нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид элсэн суралцана.
- 3.2 Эмнэлгийн мэргэжилтний хөгжил нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 үндсэн чиглэлтэй байх ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллах буюу хавсран ажиллах боломжтой.
- 3.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээрээ ахин дэвших замналыг “мэргэжлийн чиглэл” гэнэ. Энэ чиглэлийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтэн нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон


давтан сургалтад суралцахын зэрэгцээ мэргэжлийн зэрэг авч, зэргээ ахиулж болно. Мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, үнэлэх, баталгаажуулахад чиглэгдэх ба ахлах, тэргүүлэх, зөвлөх гэсэн 3 шатлалтай байна.

3.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь боловсролын зэргээ шатлан ахиулж хөгжих чиглэлийг “боловсролын чиглэл” гэнэ. Энэ чиглэлийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтэн нь магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно.


3.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь урт эсвэл богино хугацааны удирдлагын сургалтад хамрагдаж, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаснаар мерит зарчмын дагуу эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд ажиллахыг “удирдлагын чиглэл” гэнэ. Энэ чиглэлийн хүрээнд тухайн байгууллагын тасаг, нэгж, албаны даргаас эхлэн байгууллагын даргаар шатлан ажиллаж болно.

3.6 Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд мерит зарчим буюу мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлийн хэмжүүрийг мөрдлөг болгоно.

Энгийн мэргэжилтний хөгжлийн ерөнхий зураглал (GENERAL CAREER PATHWAY for MEDICAL SPECIALIST)



Хүний их эмчийн хөгжлийн загвар



1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд “Хүний их эмч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад элсэн суралцана.

1.2 Хүний их эмчийн сургалт нь 6 жилийн хугацаатай, 180 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Хүний их эмч” (Medical doctor) мэргэжилтэй, бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Хүний их эмч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн хүний их эмч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 2 жилийн хугацаатай “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч болж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт эмчээр ажиллах эрх үүснэ.

2.2 Шинэ төгссөн хүний их эмч нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хүрээлэн, төвд шууд ажиллах бол “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй. Түүнчлэн анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид эмнэл зүйн бус чиглэлээр багшлах нөхцөлд “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахгүй байж болно.

2.3 Эмнэл зүйн бус чиглэлээр ажиллаж байгаад эрүүл мэндийн байгууллагад хүний их эмчээр шилжин ажиллах тохиолдолд 2 жилийн хугацаатай “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмчээр эхэлж ажиллах шаардлагатай.

2.4 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий шинэ төгссөн хүний их эмч нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 2-оос доошгүй жил эмчээр ажилласны дараа мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцвэл 5 жилийн хугацаатай “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авна.

2.5 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их эмч нь жил бүр 6 багц баг биелүүлэх сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.6 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх 5 жилийн хугацаатай зөвшөөрөл бүхий хүний их эмч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж болно.

2.7 Үндсэн мэргэшлийн сургалт дүүргэсэн хүний их эмч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тухайн мэргэжлээрээ ажиллана.

2.8 Үндсэн мэргэшлийн сургалт дүүргэсэн хүний их эмч нь тухайн мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласны дараа цаашид төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцаж болно. Үүний тулд суралцагчдад тавих шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцсэн байх шаардлагатай.

2.9 Төрөлжсөн мэргэшлийн сургалт дүүргэсэн хүний их эмч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тухайн төрөлжсөн мэргэжлээрээ ажиллана.

2.10 Хүний их эмч нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.11 Хүний их эмч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.11.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа хүний их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

2.11.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй хүний их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;

2.11.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй хүний их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.12 Хүний их эмч нь уламжлалт анагаахын чиглэлээр шилжин ажиллах боломжгүй бөгөөд энэ тохиолдолд “Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлээр бакалаврын сургалт дүүргэх шаардлагатай.

2.13 Хүний их эмч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болох ба ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал тухайн чиглэлээрээ анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багшаар эсвэл эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагад судлаачаар ажиллаж болно.

2.14 Хүний их эмч нь удирдлагын урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл алба, тасаг, нэгж, клиникийн дарга, эрхлэгчээс эхлэн эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах боломжтой.

3. Боловсролын чиглэл

3.1 Хүний их эмч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл эмнэл зүйн шинжлэх ухаан судлал, нийгмийн эрүүл мэнд, эм зүй, био-анагаах, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Хүний их эмч нь цаашид шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын докторын зэрэгтэй хүний их эмч нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан хүний их эмч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;

3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат

дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);

3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан хүний их эмч нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд эрхлэгчээр ажиллах буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй хүний их эмч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын хувьд дээрхээс гадна мэргэжлийн тэргүүлэх эсвэл зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.

Үүний их эмчийн хөгжлийн ерөнхий (career) харгалцал (PATHWAY FOR MEDICAL DOCTOR)

Удирдлагын чиглэл

Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах

Шалгуур хангавал

Урт эсвэл богино хугацааны удирдлагын суралтад суралцах

Шалгуур хангавал

Мэргэжлийн чиглэл

Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилагч, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эмчээр ажиллах

Төрөлжсөн мэргэжлийн эмч

Төрөлжсөн мэргэжлийн суралтад суралцах 6-аас доошгүй сар

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг зэрэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллах

5 жилийн хугацаатай "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт эмчээр ажиллах 2-оос доошгүй жил

2 жилийн хугацаатай "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч

Хүний их эмч (Medical doctor)

Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд "Хүний их эмч" мэргэжлээр суралцах 6 жил (180 багц цаг)

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсвөгч болон түүнээс дээш боловсролтой ирэн
Эмнэлгийн бусад мэргэжилтэн

Боловсролын чиглэл

Шинжлэх ухааны доктор

Шалгуур хангавал

Боловсролын доктор

Докторантурт суралцах 3-аас доошгүй жил

Шалгуур хангах, эсэлтийн шалгалтад тэнцвэл

Магистр

Магистрантурт суралцах 1.5 жилээс доошгүй


Шалгуур хангах, эсэлтийн шалгалтад тэнцвэл

Ашиг тус ба Болгомж

- Мэргэжлийн зэрэгтэй хүний их эмч:
 - Цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - эмч дагалдуулан сургах
 - эмнэл зүйн сургалт удирдах
- Боловсролын зэрэгтэй хүний их эмч:
 - Цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - сургалтын байгууллагад багшлах
 - эрдэм шинжилгээний ажил эрхлэх

Эхлэл

Нүүр амны их эмчийн хөгжлийн загвар



1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд “Нүүр амны их эмч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад элсэн суралцана.

1.2 Нүүр амны их эмчийн сургалт нь 5 жилийн хугацаатай, 150 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Нүүр амны их эмч” (Dentist) мэргэжилтэй, бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Нүүр амны их эмч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн нүүр амны их эмч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч болж, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллах эрх үүснэ.

2.2 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй нүүр амны их эмч нь жил бүр 6 багц цаг биелүүлэх сургалтад суралцах үүрэгтэй.

2.3 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх 5 жилийн хугацаатай зөвшөөрөл бүхий нүүр амны их эмч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж болно.

2.4 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, үндсэн мэргэшлийн сургалт дүүргэн тухайн мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажиллаж байгаа нүүр амны их эмч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл нүүр амны төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдана.

2.5 Төрөлжсөн мэргэшлийн сургалт дүүргэсэн нүүр амны их эмч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тухайн төрөлжсөн мэргэжлээрээ ажиллана.

2.6 Нүүр амны их эмч нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.7 Нүүр амны их эмч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

- 2.7.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа нүүр амны их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;
- 2.7.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж байгаа нүүр амны их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;
- 2.7.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй нүүр амны их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”- тэй болно.

2.8 Нүүр амны их эмч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болох ба ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал тухайн чиглэлээрээ анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багшаар эсвэл эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагад судлаачаар ажиллаж болно.

2.9 Нүүр амны их эмч нь удирдлагын урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл алба, тасаг, нэгж, клиникийн дарга, эрхлэгчээс эхлэн эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах боломжтой.

3. Боловсролын чиглэл

3.1 Нүүр амны их эмч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл эмнэл зүйн шинжлэх ухаан судлал, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Нүүр амны их эмч нь цаашид шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын докторын зэрэгтэй нүүр амны их эмч нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан нүүр амны их эмч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

- 3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;
- 3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);


- 3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);
- 3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан нүүр амны их эмч нь сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд эрхлэгчээр ажиллах буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй нүүр амны их эмч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын хувьд дээрхээс гадна мэргэжлийн тэргүүлэх эсвэл зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.

Нүүр амнь, их эмчийн хөгжлийн ерөнхий зургалал (CAREER PATHWAY FOR DENTIST)



Ашиг тус ба Боломж

- Мэргэжлийн зэрэгтэй нүүр амны их эмч:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - эмч дагалдуулан сургах
 - эмнэл зүйн сургалт удирдах
- Боловсролын зэрэгтэй нүүр амны их эмч:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - сургалтын байгууллагад багшлах
 - эрдэм шинжилгээний ажил эрхлэх

Уламжлалт анагаахын их эмчийн хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд “Уламжлалт анагаахын их эмч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад элсэн суралцана.

1.2 Уламжлалт анагаахын их эмчийн сургалт нь 6 жилийн хугацаатай, 180 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Уламжлалт анагаахын их эмч” (Doctor of traditional medicine) мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Уламжлалт анагаахын их эмч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн уламжлалт анагаахын их эмч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмч болж, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллах эрх үүснэ.

2.2 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий уламжлалт анагаахын их эмч нь жил бүр 6 багц цаг биелүүлэх сургалтад суралцах үүрэгтэй.

2.3 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх 5 жилийн хугацаатай зөвшөөрөл бүхий уламжлалт анагаахын их эмч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж болно.

2.4 “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, үндсэн мэргэшлийн сургалт дүүргэн тухайн мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажиллаж байгаа уламжлалт анагаахын их эмч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл уламжлалт анагаахын төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцана.

2.5 Төрөлжсөн мэргэшлийн сургалт дүүргэсэн уламжлалт анагаахын их эмч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, клиник, амаржих газар, сувилал болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллана.

2.6 Уламжлалт анагаахын их эмч нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.7 Уламжлалт анагаахын их эмч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.7.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа уламжлалт анагаахын их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

2.7.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй уламжлалт анагаахын их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;

2.7.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй уламжлалт анагаахын их эмч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.8 Уламжлалт анагаахын их эмч нь өрнийн анагаах ухааны чиглэлээр шууд шилжин ажиллахгүй бөгөөд энэ тохиолдолд “Хүний их эмч” мэргэжлээр бакалаврын сургалт дүүргэх шаардлагатай.

2.9 Уламжлалт анагаахын их эмч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болох ба ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал тухайн чиглэлээрээ анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багшаар эсвэл эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагад судлаачаар ажиллаж болно.

2.10 Уламжлалт анагаахын их эмч нь удирдлагын урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл алба, тасаг, нэгж, клиникийн дарга, эрхлэгчээс эхлэн эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах боломжтой.

3. Боловсролын чиглэл

3.1 Уламжлалт анагаахын их эмч нь шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл уламжлалт анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Уламжлалт анагаахын их эмч нь цаашид шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын доктор нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

17

3.4 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан уламжлалт анагаахын их эмч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

- 3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;
- 3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);
- 3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);
- 3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан уламжлалт анагаахын их эмч нь удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангавал өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд эрхлэгчээр ажиллах буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй уламжлалт анагаахын их эмч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төв, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сувилалын дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын хувьд дээрхээс гадна мэргэжлийн тэргүүлэх эсвэл зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.

Уламжлалт анагаахын их эмчийн хөгжлийн зурчлал (CAREER PATHWAY for DOCTOR OF TRADITIONAL MEDICINE)

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах

Шалгуур хангавал

Удирдлагын урт эсвэл богино хугацааны сургалтад суралцах

Шалгуур хангавал

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагад уламжлалт анагаахын их эмчээр ажиллах

Төрөлжсөн мэргэжлийн эмч

Төрөлжсөн мэргэжлийн сургалтад суралцах 6-аас доошгүй сар

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Үндсэн мэргэжлийн эмч

Үндсэн мэргэжлийн сургалтад суралцах 1.5-аас доошгүй жил

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

5 жилийн хугацаатай "Эмчлэх" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй уламжлалт анагаахын их эмч

Зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл

Уламжлалт анагаахын их эмч (Doctor of traditional medicine)

Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид "Уламжлалт анагаахын их эмч" мэргэжлээр суралцах 6 жил (180 багц цаг)

Элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтвал

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛ

Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж, эрдэм судалгааны байгууллагад багш, судлаачаар ажиллах

Шинжлэх ухааны доктор

Шалгуур хангавал

Боловсролын доктор

Докторантурт суралцах 3-аас доошгүй жил

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Магистр

Магистрантурт суралцах 1.5 жилээс доошгүй

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Ашиг тус ба Боломж

- Мэргэжлийн зэрэгтэй уламжлалт анагаахын их эмч:
 - Цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - эмч дагалдуулан сургах эмнэл зүйн сургалт удирдах
- Боловсролын зэрэгтэй уламжлалт анагаахын их эмч:
 - Цалин тодорхой хувиар нэмэгдэх сургалтын байгууллагад багшлах
 - эрдэм шинжилгээний ажил эрхлэх

Уламжлалт анагаахын их эмч нь өрнийн анагаах ухааны чиглэлээр шилжин ажиллахгүй бөгөөд энэ тохиолдолд "Хүний их эмч" мэргэжлээр бакалаврын сургалт дүүргэх шаардлагатай.

Элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтвал

Эхлэл

- Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөөч болон түүнээс дээш боловсролтой ирвэн

- Эмнэлгийн бусад мэргэжилтэн

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5
дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн”-ээр бакалаврын боловсролын сургалтад элсэн суралцана.

1.2 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний сургалт нь 5 жилийн хугацаатай, 150 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн”(Public health specialist)-ээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг болон нийгмийн эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв, эрдэм шинжилгээний байгууллага, эрүүл мэндийн бусад байгууллагад нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнээр ажиллана.

2.2 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй.

2.3 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.4 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд нийгмийн эрүүл мэндийн мэргэшүүлэх сургалтад суралцана.

2.5 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.5.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

2.5.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;

2.5.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.6 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно.

2.7 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн удирдлагын урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл алба, тасаг, нэгжийн дарга, эрхлэгчээс эхлэн эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах боломжтой.

3. Боловсролын чиглэл

3.1 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр 1.5-аас доошгүй жил суралцан, магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь цаашид шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy -Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын докторын зэрэгтэй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Хүний их эмч, нүүр амны их эмч, уламжлалт анагаахын их эмч, эм зүйч, бакалаврын боловсролтой сувилагч, био-анагаахын мэргэжилтэн зэрэг эмнэлгийн мэргэжилтнээс гадна байгалийн шинжлэх ухаан, эдийн засаг, нийгмийн ухаан, хууль эрх зүй зэрэг бусад чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн иргэд шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл нийгмийн эрүүл мэндийн магистр, докторын сургалтад шатлан суралцаж болно.

3.5 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.5.1 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);


- 3.5.2 өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг болон нийгмийн эрүүл мэндийн төв, байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв зэрэг тусгай мэргэжлийн төвд мэргэжлээрээ;
- 3.5.3 нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);
- 3.5.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд эрхлэгчээр ажиллах буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг ханган, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой.

Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний хөгжлийн зураглал (CAREER PATHWAY for PUBLIC HEALTH SPECIALIST)



УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд шатлан ажиллах

Шалгуур хангаавал

Урт эсвэл богино хугацааны удирдлагын суралтад суралцах

Шалгуур хангаавал

Ашиг тус ба Боломж

- Мэргэжлийн зэрэгтэй НЭМ-ийн мэргэжилтэн:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - бусад мэргэжилтнийг дагалдуулан сургах
 - сургалт удирдах
- Боловсролын зэрэгтэй НЭМ-ийн мэргэжилтэн:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - сургалтын байгууллагад багшлах
 - эрдэм шинжилгээний ажил эрхлэх

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

Мэргэжлийн зэрэгтэй НЭМ-ийн мэргэжилтэн

Зөвлөх

Таруулах

Ахлах

Шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнээр ажиллах

НЭМ-ийн мэргэжлээр ажиллах

Мэргэшүүлэх суралтад суралцах 6-аас доошгүй сар

Шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнээр ажиллах

Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн (Public Health specialist)

Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид "Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн"-ээр суралцах 5 жил (150 багц цаг)

Элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтавал

Эхлэл

- Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөөч болон түүнээс дээш боловсролтой иргэн
- Эмнэлгийн мэргэжилтэн

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛ

Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагад багш, судлаачаар ажиллах

Шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Шинжлэх ухааны доктор

Боловсролын доктор

Докторантурт суралцах 3-аас доошгүй жил

Шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Магистр

Магистрантурт суралцах 1.5-аас доошгүй жил

Шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Эмнэлгийн мэргэжилтнээс гадна байгалийн шинжлэх ухаан, эдийн засаг, нийгмийн ухаан, хууль эрх зүй зэрэг бусад чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн иргэд шалгуур хангааж, элсэлтийн шалгалтад тэнцвэл нийгмийн эрүүл мэндийн магистр, докторын сургалтад шатлан суралцах болно.

Био-анагаахын мэргэжилтний хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн хяналтын тоонд багтсан нөхцөлд нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид “Био-анагаах”-ын чиглэлээр бакалаврын боловсролын сургалтад элсэн суралцана.

1.2 Био-анагаахын мэргэжилтний сургалт нь 5 жилийн хугацаатай, 150 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Био-анагаахын мэргэжилтэн” (Biomedical specialist)-ээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Био-анагаахын мэргэжилтэн нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн био-анагаахын мэргэжилтэн нь төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, тухайлбал лаборатори, цус сэлбэлт, судлалын байгууллага, эрхтэн шилжүүлэн суулгах төв, эмийн үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллага, нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв зэрэг байгууллагад мэргэжлээрээ ажиллаж болно.

2.2 Био-анагаахын мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй.

2.8 Био-анагаахын мэргэжилтэн нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.9 Био-анагаахын мэргэжилтэн нь элсэлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд био-анагаахын мэргэшүүлэх сургалтад суралцана. Үүнд: дархлаа судлал, микробиологи, клиникийн эм зүй, эрхтэн шилжүүлэн суулгах, цус судлал, эд судлал, эс судлал, вирус судлал гэх мэт чиглэлээр төрөлжин суралцах боломжтой.

2.10 Био-анагаахын мэргэжилтэн нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

- 2.10.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа био-анагаахын мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;
- 2.10.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй био-анагаахын мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй,
- 2.10.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй био-анагаахын мэргэжилтэн нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.11 Био-анагаахын мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болох ба тухайн мэргэжлээрээ эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болно.

3. Боловсролын чиглэл

3.1 Био-анагаахын мэргэжилтэн нь шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл био-анагаах, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Био-анагаахын мэргэжилтэн нь цаашид шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy -Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын докторын зэрэгтэй био-анагаахын мэргэжилтэн нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, хүний их эмч, эм зүйч зэрэг эмнэлгийн мэргэжилтэн, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн иргэд шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл био-анагаахын магистр, докторын сургалтад шатлан суралцаж болно.

3.5 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан био-анагаахын мэргэжилтэн нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

- 3.5.1 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);
- 3.5.2 лаборатори, цус сэлбэлт судлалын байгууллага, эрхтэн шилжүүлэн суулгах төв, нийгмийн эрүүл мэндийн төв, байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв зэрэг тусгай мэргэжлийн төвд мэргэжлээрээ;
- 3.5.3 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.5.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн био-анагаахын мэргэжилтэн нь алба, тасаг, нэгж, клиникийн дарга, эрхлэгчээс эхлэн эрүүл мэндийн байгууллагын зохих удирдах албан тушаалд шатлан ажиллах боломжтой.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг ханган, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй био-анагаахын мэргэжилтэн нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төв зэрэг эрүүл мэндийн байгууллагад дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой.

24

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5
дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар
тушаалын долоодугаар хавсралт

Эм зүйчийн хөгжлийн загвар



1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид “Эм зүйч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад суралцана.

1.2 Эм зүйчийн сургалт нь 5 жилийн хугацаатай, 150 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Эм зүйч” (Pharmacist) мэргэжилтэй, бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Эм зүйч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн эм зүйч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эм зүйч болж, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллах эрх үүснэ.

2.2 “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий шинэ төгссөн эм зүйч нь эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн хяналтын алба, эмнэлгийн лаборатори, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, клиник, амаржих газар зэрэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллана.

2.3 “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эм зүйч нь жил бүр 6 багц цаг биелүүлэх сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.4 Эм зүйч нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.5 “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажиллаж байгаа эм зүйч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцана.

2.6 Эм зүйч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтадорж болно. Үүнд:

- 2.6.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа эм зүйч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;
- 2.6.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй эм зүйч нь шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;
- 2.6.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй эм зүйч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.11 Эм зүйч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа магистр, докторын сургалтад суралцаж, магистр, боловсролын доктор, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болох ба ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал тухайн чиглэлээрээ анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багшаар эсвэл эрдэм, шинжилгээ судалгааны байгууллагад судлаачаар ажиллаж болно.

3. Боловсролын чиглэл

3.1 Эм зүйч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл эм зүй, нийгмийн эрүүл мэнд, био-анагаах, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Эм зүйч нь цаашид шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын доктор нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэгтэй эм зүйч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

- 3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;
- 3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);
- 3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);
- 3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан эм зүйч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангавал сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд эрхлэгчээр ажиллах буюу эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн хяналтын алба, эмнэлгийн лаборатори, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, амаржих газар зэрэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Эрүүл мэндийн байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй эм зүйч нь эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн хяналтын алба, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дарга, захирлын албан тушаалд ажиллах боломжтой.

Эм зүйчийн хөгжлийн зураглал (CAREER PATHWAY for PHARMASIST)

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын удирдих албан тушаалд шатлан ажиллах

Шалгуур хангавал

Удирдлагын урт, богино хугацааны сургалтад хамрагдах

Шалгуур хангавал

Ахлах Таруулж Зөвлөх

Мэргэжлийн зэрэгтэй эм зүйч

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

Төрийн болон хувийн хэвшлийн эмийн сан, эм хангаан нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн хяналтын алба, лаборатори, эмнэлэг, бусад эрүүл мэндийн байгууллагад ажиллах

Төрөлжсөн мэргэшлийн эм зүйч

Төгсөлтийн дараах мэргэжлүүлэх сургалтад суралцах 6-аас доошгүй сар

Төрийн болон хувийн хэвшлийн эмийн сан, эм хангаан нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн хяналтын алба, лаборатори, эмнэлэг, бусад эрүүл мэндийн байгууллагад ажиллах

Эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эм зүйч

Зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл

Эм зүйч (Pharmacist)

Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид "Эм зүйч" мэргэжлээр суралцах 5 жил (150 багц цаг)

Элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцж, хяналтын тусанд багтвал

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн
Эмнэлийн бусад мэргэжилтэн

Эхлэл

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛ

анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагад багш, судлаачаар ажиллах

Магистрантурт суралцах 1.5-аас доошгүй жил

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Шинжлэх ухааны доктор

Шалгуур хангавал

Боловсролын доктор

Докторантурт суралцах 3-аас доошгүй жил

Шалгуур хангах, элсэлтийн шалгалтад тэнцвэл

Магистр

Ашиг тус ба Боломж

- Мэргэжлийн зэрэгтэй эм зүйч нь:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - эм зүйч дагалдуулан сургах сургалт удирдах
- Боловсролын зэрэгтэй эм зүйч нь:
 - цалин тодорхой хувиар нэмэгдэх
 - сургалтын байгууллагад багшлах
 - эрдэм шинжилгээний ажил эрхлэх

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5
дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар
тушаалын наймдугаар хавсралт



Сувилагчийн хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

1.1 Туслах сувилагч болон дипломын, бакалаврын боловсролын зэрэг олгох гэсэн 3 шатлал бүхий сургалтаар сувилагчийг бэлтгэнэ.

1.2 Суурь боловсролтой иргэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид "Туслах сувилагч" мэргэжлээр суралцана.

1.3 Туслах сувилагчийн сургалт нь 1 жилийн хугацаатай, 44 багц цагийн багтаамжтай байна.

1.4 Туслах сувилагч нь сувилахуйн дипломын, бакалаврын боловсролын зэрэг олгох сургалтад суралцахын тулд элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтах шаардлагатай.

1.5 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид "Сувилагч" мэргэжлээр дипломын болон бакалаврын боловсрол олгох сургалтад шатлан суралцана.

1.6 Сувилахуйн дипломын сургалт нь 3 жилийн хугацаатай, 90 багц цагийн багтаамжтай байна.

1.7 Сувилахуйн бакалаврын боловсролын сургалт нь 4 жилийн хугацаатай, 120 багц цагийн багтаамжтай байна.

1.8 Дипломын боловсролтой сувилагч нь багц цаг тооцсоны үндсэн дээр үргэлжлүүлэн суралцан бакалаврын боловсрол эзэмшиж болно. Ингэхдээ эрүүл мэндийн байгууллагад тодорхой хугацаанд ажилласны дараа эсвэл дипломын боловсрол олгох сургалтыг дүүргэн шууд суралцаж болно.

1.9 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд "Туслах сувилагч" (Assistant nurse), "Дипломын боловсролтой сувилагч" (Diploma nurse), "Бакалаврын боловсролтой сувилагч" (Bachelor nurse) мэргэжлээр тус тус төгсөнө.

1.10 Сувилагч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Туслах сувилагч нь “сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй ба төр, хувийн хэвшлийн бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагад дипломын, бакалаврын боловсролтой сувилагчийн удирдлага дор асаргаа, сувилгаа хийх үндсэн үүрэгтэй ажиллана.

2.2 Дипломын, бакалаврын боловсролтой сувилагч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй болж, төр, хувийн хэвшлийн бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагад сувилагчаар ажиллах эрх үүснэ.

2.3 “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий сувилагч нь жил бүр 3 багц цаг биелүүлэх сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.4 Сувилагч нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад суралцаж болох ба ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.5 Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан, “сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий сувилагч нь суралцагчдад тавих шалгуурыг хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцаж болно.

2.6 Төрөлжсөн мэргэшлийн сургалт дүүргэсэн сувилагч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал төр, хувийн хэвшлийн бүх төрлийн эрүүл мэндийн байгууллагад төрөлжсөн мэргэжлээрээ ажиллана.

2.7 Дипломын, бакалаврын боловсролтой сувилагч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.7.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа сувилагч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

2.7.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй сувилагч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй;

2.7.3 “Тэргүүлэх зэрэг”-тэй, 20 ба түүнээс дээш жил ажиллаж буй сувилагч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Зөвлөх зэрэг”-тэй болно.

2.8 Бакалаврын боловсролтой сувилагч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистрын, боловсролын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болно.

3. Боловсролын чиглэл

3.1 Бакалаврын боловсролтой сувилагч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл сувилахуй, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан магистрын зэрэг хамгаалж болно.

3.2 Магистрын зэрэгтэй сувилагч нь цаашид шалгуур хангаж, шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.3 Боловсролын докторын зэрэгтэй сувилагч нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан сувилагч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;

3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтнаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);


3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан сувилагч нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилал, амаржих газар, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн холбогдох алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.

4.2 Ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл эрүүл мэндийн байгууллагын бусад удирдах албан тушаалд ажиллаж болно.

Сувгагчийн хөгжлийн зураглал (CAREER PATHWAY for NURSE)



Эх баригчийн хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид “Эх баригч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад суралцана.

1.2 Эх баригчийн сургалт нь 4 жилийн хугацаатай, 120 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Эх баригч” (Midwife) мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Эх баригч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн эх баригч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “эх барих” мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй болж, эрүүл мэндийн байгууллагад ажиллах эрх үүснэ.

2.2 “Эх барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий шинэ төгссөн эх баригч нь тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангавал сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, клиник, амаржих газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төв зэрэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллана.

2.3 “Эх барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эх баригч нь жил бүр 3 багц цаг биелүүлэх сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.4 Эх баригч нь ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.5 Эх баригч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.5.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа эх баригч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

2.5.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй эх баригч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй болно.

2.6 Эх баригч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистрын, боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болно.

3. Боловсролын чиглэл

3.1 Эх баригч нь бусад эмнэлгийн мэргэжлээр элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их дээд, сургууль, коллежид эмнэлгийн бусад мэргэжлээр суралцаж болно.

3.2 Эх баригч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл эх барихуй, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан, магистрын зэрэг хамгаалж болно.

3.3 Магистрын зэрэгтэй эх баригч нь цаашид шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy) хамгаалж болно.

3.4 Боловсролын докторын зэрэгтэй эх баригч нь шалгуур хангавал шинжлэх ухааны докторын зэрэг (Doctor of Science – Sc.D) хамгаалж болно.

3.5 Магистрын, боловсролын докторын, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан эх баригч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.5.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;

3.5.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.5.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтнаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);

3.5.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан эх баригч нь сумын эрүүл мэндийн

төв, сум дундын эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, клиник, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төвийн холбогдох алба, тасаг, нэгжийн даргаар ажиллаж болно.


4.2 Ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл эрүүл мэндийн байгууллагын бусад удирдах албан тушаалд ажиллаж болно.

Эх баригчийн хөгжлийн зураглал (CAREER PATHWAY FOR MIDWIFE)

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛ

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛ



Цаашид хөгжлийн зураглал аль мэргэжлийг сонгосноос хамаарна
Хүний их эмч, нийэмийн эрүүл мэндийн чиглэлээр дөвшин суралцаж болно.

Эх баригч (Midwife)
Анагаах ухааны боловсрол олгох сургууль, коллежид "Эх баригч" мэргэжлээр суралцах 4 жил (120 багц цаг)
Эхсэлтийн өрөнхий шалгалтад тэнцэх, хичээлийн тооног бөглөх
- Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн
- Эмнэлгийн бусад мэргэжилтэн

Ашиг тус ба Боломж
1. Мэргэжлийн зэрэгтэй эх баригч нь:
- цалин тодорхой хувиар нэмэгдэх
- эх баригч дагалдуулан сургах
- сургалт удирдах
2. Боловсролын зэрэгтэй эх баригч нь:
- цалин тодорхой хувиар нэмэгдэх
- сургалтын байгууллагад багшлах
- эрдэм шинжилгээний ажил эрхлэх

28

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5
дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар
тушаалын аравдугаар хавсралт

Эм найруулагчийн хөгжлийн загвар



1. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч болон түүнээс дээш боловсролтой иргэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид “Эм найруулагч” мэргэжлээр бакалаврын боловсролын сургалтад суралцана.

1.2 Эм найруулагчийн сургалт нь 4 жилийн хугацаатай, 120 багц цагийн багтаамжтай байна.

1.3 Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Эм найруулагч” (Pharmacy technician) мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.

1.4 Эм найруулагч нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

2.1 Шинэ төгссөн эм найруулагч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцвэл 5 жилийн хугацаатай “эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эм найруулагч болж, эрүүл мэндийн байгууллагад ажиллах эрх үүснэ.

2.2 “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий шинэ төгссөн эм найруулагч нь тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангавал эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр зэрэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллана.

2.3 “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эм найруулагч нь жил бүр 3 багц цаг биелүүлэх сургалтад суралцах үүрэгтэй.

2.4 Эм найруулагч нь ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.

2.5 Эм найруулагч нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:

2.5.1 Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа эм найруулагч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;

40

2.5.2 “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй эм найруулагч нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй болно.

2.6 Эм найруулагч нь эрүүл мэндийн байгууллагад ажиллах явцдаа шалгуур хангавал магистр, докторын сургалтад суралцаж, магистрын, боловсролын докторын зэрэг хамгаалж болно. Энэ тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болно.

3. Боловсролын чиглэл

3.1 Эм найруулагч нь бусад эмнэлгийн мэргэжлээр элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их дээд, сургууль, коллежид эмнэлгийн бусад мэргэжлээр суралцаж болно.

3.2 Эм найруулагч нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл эм зүй, нийгмийн эрүүл мэнд, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан, магистрын зэрэг хамгаалж болно.

3.3 Магистрын зэрэгтэй эм найруулагч нь цаашид шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын зэрэг хамгаалсан эм найруулагч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;

3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтнаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);


3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4. Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан эм найруулагч нь эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмнэлгийн байгууллага зэрэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох алба, тасаг, нэгжийн даргаар шат дараалан ажиллаж болно.

4.2 Ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл эрүүл мэндийн байгууллагын бусад удирдах албан тушаалд ажиллаж болно.

Эм найруулагчийн хөгжлийн ерөнхий зурвас (CAREER PATHWAY for PHARMACIST TECHNICIAN)



43

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5
дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар
тушаалын арваннэгдүгээр хавсралт



Эмнэлгийн лаборантын хөгжлийн загвар

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Суурь боловсролтой болон ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгч, эмнэлгийн бусад мэргэжилтэн элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид “Эмнэлгийн лаборант” мэргэжлээр суралцана
- 1.2. Эмнэлгийн лаборантын сургалт нь 4 жилийн хугацаатай, 120 багц цагийн багтаамжтай сургалт байна.
- 1.3. Багц цаг хангаж, төгсөлтийн шалгалтад тэнцсэн нөхцөлд “Эмнэлгийн лаборант” (Medical laboratory technician) мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөнө.
- 1.4. Эмнэлгийн лаборант нь мэргэжлийн, боловсролын, удирдлагын гэсэн 3 чиглэлийн аль нэгээр цаашид хөгжих боломжтой ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллаж болно.

2. Мэргэжлийн чиглэл

- 2.1. Эмнэлгийн лаборант нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүй ба тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангавал төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллана.
- 2.2. Эмнэлгийн лаборант нь ажилласан 3-5 жил тутамд Эрүүл мэндийн тухай хууль, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу давтан сургалтад хамрагдах үүрэгтэй.
- 2.3. Эмнэлгийн лаборант нь ажиллах хугацаандаа мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орж болно. Үүнд:
 - 2.3.1. Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж байгаа эмнэлгийн лаборант нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Ахлах зэрэг”-тэй;
 - 2.3.2. “Ахлах зэрэг” хамгаалснаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж буй эмнэлгийн лаборант нь шалгуур хангаж, зэргийн шалгалтад тэнцвэл “Тэргүүлэх зэрэг”-тэй болно.

3 Боловсролын чиглэл

3.1 Эмнэлгийн лаборант нь бусад эмнэлгийн мэргэжлээр элсэлтийн ерөнхий шалгалтад тэнцэж, тухайн жилийн оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан нөхцөлд анагаах ухааны боловсрол олгох их дээд, сургууль, коллежид эмнэлгийн бусад мэргэжлээр суралцаж болно.

3.2 Эмнэлгийн лаборант нь шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл нийгмийн эрүүл мэнд, био-анагаах, удирдлагын чиглэлээр магистрын сургалтад 1.5-аас доошгүй жил суралцан, магистрын зэрэг хамгаалж болно.

3.3 Магистрын зэрэгтэй эмнэлгийн лаборант нь цаашид шалгуур хангаж, элсэлтийн шалгалтад тэнцвэл докторын сургалтад 3-аас доошгүй жил суралцаж, боловсролын докторын зэрэг (Doctor of Philosophy-Ph.D) хамгаалж болно.

3.4 Магистрын, боловсролын докторын зэрэг хамгаалсан эмнэлгийн лаборант нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангавал дараах ажлын байранд ажиллах боломжтой:

3.4.1 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ үргэлжлүүлэн;

3.4.2 анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежид багш, ахлах багш, профессороор шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн сургууль гаргана);

3.4.3 эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтнаар шат дараалан болон эрүүл мэндийн байгууллагад хавсран (тавигдах шаардлагыг тухайн байгууллага гаргана);

3.4.4 эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалд тус тус ажиллаж болно.

4 Удирдлагын чиглэл

4.1 Эрүүл мэндийн байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын чиглэлээр урт эсвэл богино хугацааны сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан эмнэлгийн лаборант нь төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох тасаг, нэгжийн даргаар шат дараалан ажиллаж болно.

4.2 Ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлага хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцвэл эрүүл мэндийн байгууллагын бусад удирдах албан тушаалд ажиллаж болно.

Эмнэлгийн лаборантын хөгжлийн зураглал (CAREER PATHWAY for LAB TECHNICIAN)

